

*Хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлцгээе!*



Сургуулийн орчинд  
үе тэнгийнхний  
дээрэлхэлт, ялгаварлан  
гадуурхалтыг зогсоох  
нөхцөл, боломж



*Сэтгэл судлалын ухааны доктор, профессор Д.Санжжавын нэрэмжит  
Эрдэм шинжилгээний хурал*

**Зорилго:** Үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, сургуулийн орчин дахь дарамт, дээрэлхэлтийг зогсоох сэтгэлзүйн эрүүл, ээлтэй орчинг бүрдүүлэхэд онол, практикийн ач холбогдол бүхий судалгаа, шинэлэг, бүтээлч санааг дэмжих, хөгжүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх.

**Хамрах хүрээ:** Эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, ерөнхий боловсрол, коллеж, их, дээд сургуулийн багш, професор, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч, докторант, магистрант, залуу судлаачид оролцох боломжтой.

**Илтгэлийн хураангуйг хүлээн авах:** Эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлэх илтгэлийг 2022.04.25-ны өдрийн 17.00 хүртэл [info@usp.mn](mailto:info@usp.mn) и-мэйл хаягаар хүлээн авна.

**Шалгаруулалт, хурлын тов:** Шаардлага хангасан бүх илтгэлийн дэлгэрэнгүйг эмхэтгэл болгон хэвлүүлэх ба шалгарсан 8-10 илтгэлийн хэлэлцүүлгийг 2022.04.28-нд зохион байгуулж шилдэг 3 илтгэлийг шалгаруулна. /Ppt программ дээр бэлтгэсэн байх, илтгэлээ танилцуулах хугацаа 15 минут байна/

Лавлах утас: 95081001, 90352222, 90652222

### **Илтгэлийн хураангуйд тавих шаардлага:**

1. Илтгэлийн хураангуйг Word-2016 болон түүнээс өмнөх программ ашиглан Монгол хэл дээр бэлтгэх ба дараах бүтэцтэй байна:
  - Үндэслэл
  - Зорилго
  - Агуулга, арга зүй
  - Үр дүн
  - Дүгнэлт
  - Санал, зөвлөмж
2. Хураангуйн нүүр гарчгийг үсгийн 12 хэмжээтэй, **Bold** хэлбэрээр бичих бөгөөд гарчгийн дор судлаачдын нэрс, харъяа байгууллагын нэрсийг үсгийн 9 хэмжээтэй товчлохгүй бичнэ. Мөн оролцогчдын и-мэйл хаяг, холбогдох утасны дугаарыг бичсэн байна
3. Хураангуйн үндсэн тесктийн үсгийн хэмжээ 10, мөр хоорондын зай 1.15, 2 талаасаа тэнцүүлсэн, цаасны А4 хэмжээтэй 4 нүүрнээс илүүгүй бичнэ.
4. Илтгэлийн хураангуйд хүснэгт, график, зураг оруулахгүй ба зайлшгүй шаардлагатай бол үндсэн текстийн ард хавсралт хэлбэрээр оруулж болно.
5. Хураангуйн word файлын нэрийг бичихдээ оролцогч магистрант бол М, магистр бол Е, докторант бол D, доктор бол F, судлаач бол S гэж бичээд доогуур зураас (\_), криллээр илтгэгчийн нэр, доогуур зураас, утасны дугаараа бичиж [info@usp.mn](mailto:info@usp.mn) и-мэйл хаягаар илгээнэ үү!

### **Шалгуур үзүүлэлт:**

- Үндсэн үзүүлэлт (тус бүр 3-10 оноо);
  1. Шинжлэх ухаанч байдал
  2. Сэдэв, агуулгын өмнө нь судлагдсан байдал
  3. Илтгэлийн бүтээлч санаа, шинэлэг тал
  4. Илтгэлийн судалгааны үр дүн, ач холбогдол
- Шалгарсан илтгэлийн нэмэлт үзүүлэлт (тус бүр 1-5 оноо):
  1. Илтгэх, тайлбарлах үр чадвар
  2. Танилцуулга /слайд/ бэлтгэсэн байдал
  3. Асуултанд хариулсан байдал
  4. Хугацаа барилт

### **Шагнал:**

1. Тэргүүн байр: Өргөмжлөл, 500.000 төг
2. Дэд байр: Өргөмжлөл, 300.000 төг
3. Гутгаар байр: Өргөмжлөл, 200.000 төг

**Бүртгэлийн хураамж:** 20.000 төгрөг (Хас Банк: 500-998-490 тоот Нийгэм сэтгэл судлалын ДС дансаар шилжүүлнэ. Гүйлгээний утга дээр нэр, утасны дугаараа бичнэ)

ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ!

**НИЙГЭМ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛЬ**

2022-03-22